



## БАЯНЗУРХ ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 101/ШЗ2022/26700

Улаанбаатар хот

### Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Янжиндулам би,

нэхэмжлэгч- Баянзүрх дүүрэг, 5-р хороо, өөрийн байранд байрлах, Монгол кино нэгтгэл ТӨҮГ /2119811/-ийн нэхэмжлэлтэй,

хариуцагч- Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, 13-р хороолол, Эн Эм Си Жи ХХК /2021625/-д холбогдох,

18,000,000 төгрөг гаргуулахыг хүссэн нэхэмжлэлтэй иргэний хэргийг хянаад

### ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч “Монгол кино нэгтгэл” ТӨҮГазар нь хариуцагчаар “Эн Эм Си Жи” ХХК-г тодорхойлон татаж, түүнд холбогдуулан цахилгааны дэд станцыг шинэчлэн, хэрэглэгчийг хүчдэлд холбох гэрээний үүрэгт 18,000,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

### ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч “Монгол кино нэгтгэл” ТӨҮГазар нь “Эн Эм Си Жи” ХХК-нд холбогдуулан 18,000,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасныг шүүх 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хүлээн авч, 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр иргэний хэрэг үүсгэсэн.

Хариуцагч “Эн Эм Си Жи” ХХК-ийг шүүхэд дуудан ирүүлэхээр нэхэмжлэгчийн тодорхойлсон Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, 13-р хороолол гэсэн хаягаар шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлэхэд баталгаат шуудангийн 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн магадалгаанд “хаягт алдаатай” гэх тайлбар бичигдсэн Баг, хорооны тодорхойлолт хэсэгт “дээрх хаяг тус хороонд байдаггүй” болохыг тухайн хорооны засаг дарга тодорхойлж, гарын үсэг зурж, тамга дарсан байна.

Түүнчлэн нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангах хуулийн зохицуулалттай бөгөөд хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.3-т зааснаар хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, оршин байгаа газрыг нэхэмжлэлд тусгасан байх шаардлагатай.

Гэтэл нэхэмжлэгч нь хариуцагчийн хаягийг Баянзүрх дүүрэг, 6 дугаар хороо, 13-р хороолол гэж тодорхойлсон нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасан хариуцагчийн хаяг тодорхойгүй

000086955

байна.

Нэхэмжлэлд хариуцагчийн хаяг бүрэн бус дутуу бичигдсэнээр, хариуцагчаар татагдсан этгээдийн хаяг тодорхойгүй тохиолдолд түүнийг шүүхэд дуудан ирүүлэх, шүүхийн мэдэгдэх хуудсыг хүргүүлэх боломжгүй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9 дэх хэсэгт “хариуцагчийн хаяг тодорхойгүй бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана” гэж, мөн хуулийн 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэгт “энэ хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9 дэх хэсэгт заасан үндэслэл иргэний хэрэг үүсгэснээс хойш тогтоогдвол хэргийг хэрэгсэхгүй болгоно” гэж тус тус заасан.

Иймд нэхэмжлэгчийн тодорхойлсон хаяг алдаатай болохыг тухайн хороонд байдаггүй болохыг Баянзүрх дүүргийн 6-р хорооны засаг дарга тодорхойлж, нэхэмжлэлд хариуцагчийн хаяг бүрэн бус дутуу бичигдсэний улмаас шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй байх тул Монгол кино нэгтгэл ТӨҮГазрын нэхэмжлэлтэй хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж үзэв.

Хэргийг хэрэгсэхгүй болгох нь эрх зүйн маргааныг шийдвэрлэж буй бус харин энэ маргааныг шүүх шийдвэрлэх боломжгүй буюу хариуцагчийн хаяг тодорхойгүй байх тул нэхэмжлэгч нь хариуцагчийн оршин байгаа хаягийг тодорхойлж, харьяалах шүүхэд дахин нэхэмжлэлээ гаргах эрх нь нээлттэй болохыг дурдах нь зүйтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1, 123 дугаар зүйлийн 123.1-д заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасныг баримтлан “Эн Эм Си Жи” ХХК-нд холбогдуулан 18,000,000 төгрөг гаргуулахыг хүссэн “Монгол кино нэгтгэл” ТӨҮГазрын нэхэмжлэлтэй иргэний хэргийг хэрэгсэхгүй болгосугай.

2. Нэхэмжлэгч нь хариуцагчийн хаягийг тодруулан харьяалах шүүхэд нь дахин нэхэмжлэл гаргах, эсхүл оршин суугаа газар нь мэдэгдэхгүй бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 155 дугаар зүйлийн 155.2-д зааснаар түүнийг эрэн сурвалжуулах тухай хүсэлтийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргах эрхтэй болохыг тайлбарласугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасныг баримтлан нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид 202-09-08-ны өдөр төлсөн 247,950 төгрөгийг төрийн сангийн данснаас буцаан гаргуулж, Монгол кино нэгтгэл ТӨҮГ-т олгосугай.

4. Уг захирамжийг нэхэмжлэгч эс зөвшөөрвөл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д зааснаар гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг тайлбарласугай.

ШҮҮГЧ



Д.ЯНЖИНДУЛАМ